



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинээр боловсруулсан 3.29, 3.30, 3.31, 3.32 хяналтын хуудсыг нэгдүгээр хавсралтаар, шинэчлэн боловсруулсан 1.21, 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.2, 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.8.1, 3.8.2, 3.8.3, 3.10, 3.11.1, 3.11.2, 3.18, 3.20, 3.24, 3.25, 3.26, 3.28.1, 3.28.2, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.7 хяналтын хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хяналтын хуудсуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газар, Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2013 оны "Хяналтын хуудас батлах тухай" 13 дугаар тушаалын 3.8.1, 3.8.2, 3.8.3, 2013 оны "Хяналтын хуудас батлах тухай" 143 дугаар тушаалын 3.25, 3.26, 2014 оны "Хяналтын хуудас батлах тухай" 72 дугаар тушаалын 3.10, 3.18, 2015 оны "Хяналтын хуудас батлах тухай" 51 дүгээр тушаалын 1.21, 2015 оны "Хяналтын хуудас батлах тухай" 542 дугаар тушаалын 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.2, 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.11.1, 3.11.2, 3.20, 3.24, 3.28.1, 3.28.2 кодтой хяналтын хуудсуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар /М.Наранбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЦАГААНХҮҮ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 24 ны өдрийн
4/36 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ШИНЭЭЭР БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	Хяналтын хуудасны тоо
1	3.29	Зочид буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
2	3.30	Өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1
3	3.31	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгалын төвлөрсөн байгууламжийг шалгах хяналтын хуудас	1
4	3.32	Сум, тосгоны эрүүл мэндийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			4

oo0oo

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	Хяналтын хуудасны тоо
1	1.21	Тамхины үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
2	3.1.1	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
3	3.1.2	Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах хяналтын хуудас	1
4	3.1.3	Эмнэлгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1
5	3.1.4	Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
6	3.2	Эм, биобэлдмэлийн үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
7	3.3	Эмийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
8	3.6	Цэцэрлэгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
9	3.7	Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
10	3.5	Ундны усны чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
11	3.8.1	Тусгай мэргэжлийн оргүй төвүүдийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
12	3.8.2	Тусгай мэргэжлийн оргүй төвийн эм зүйн тусламж үйлчилгээг шалгах хяналтын хуудас	1
13	3.8.3	Тусгай мэргэжлийн оргүй төвийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1
14	3.10	Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
15	3.11.1	Сувиллын оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
16	3.11.2	Сувиллын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1
17	3.18	Хүүхдийн зуслангийн эрүүл, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
18	3.20.1	Клиникийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	1
19	3.20.2	Клиникийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас	1

20	3.24	Дотуур байрны эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
21	3.25	Их, дээд сургуулийн эрүүл ахуйн нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
22	3.26	Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас	1
23	3.28.1	Эмнэлзүйн лабораторийн оношилгооны чанар, аюулгүй байдлыг үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
24	3.28.2	Эмнэлзүйн лабораторийн биоаюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			24

oo0oo